

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/33/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2024 он

Санхүү, нийцлийн аудитын аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 51-261740 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn
Ахлах аудитор: Э.Энхбаатар
Утас: 51-261885 Цахим хаяг: enkhbaatare@audit.gov.mn
Аудитор: О.Наранбат
Утас: 51-261885 Цахим хаяг: naranbato@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН
САЙД Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА

2024.04.25 № 1137

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн чадавхыг тогтвортой, хүртээмжтэй дээшлүүлэх зорилгын хүрээнд тайлант онд Засгийн газрын 2023 оны 271 дүгээр тогтоолоор “Монголын эдийн засгийн чуулган-2023” арга хэмжээ болон Дэлхийн экспортыг дэмжих олон улсын чуулган уулзалтыг зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Засгийн газрын 2023 оны 161 дүгээр тогтоолоор Эдийн засаг, хөгжлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаарыг, Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2023 оны А/54 дүгээр тушаалаар яамны 2023-2025 онд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг шинэчлэн баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Эдийн засаг хөгжлийн сайдын үндсэн хэрэгжүүлэх 10 зорилт, 17 арга хэмжээнээс 13 арга хэмжээ 100 хувийн, 3 арга хэмжээ 90.0 хувийн, 1 арга хэмжээ 70 хувийн, ерөнхий дүнгээр 96.5 хувийн хэрэгжилттэй байна гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	919,894,144.8	1,250,317,006.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,200,402.2	105,274,602.1
33	АВЛАГА	709,231.1	205,353.1
34	УРЬДЧИЛГАА	1,021.0	22,516.8
35	БАРАА МАТЕРИАЛ	541,164.8	595,586.8
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	905,442,325.7	1,144,218,947.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	58,149,083.1	44,978,178.5
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	58,149,083.1	44,978,178.5
39200	Биет хөрөнгө	51,847,363.3	38,692,706.1
39300	Биет бус хөрөнгө	6,301,719.8	6,285,472.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	978,043,227.9	1,295,295,184.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	6,352,339.1	4,606,091.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	6,352,339.1	4,606,091.0
41300	Өглөг	6,352,207.9	4,606,091.0
41400	Урьдчилж орсон орлого	131.2	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	971,690,888.8	1,290,689,094.0
51	Засгийн газрын хувь оролцоо	971,690,888.8	1,290,689,094.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	7,966,285.9	7,966,285.9
51200	Хуримтлагдсан үр дүн	963,298,157.2	1,282,296,362.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	426,445.7	426,445.7
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	978,043,227.9	1,295,295,184.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	985,365,328.2	384,152,739.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	674,494,237.1	94,248,026.4
120	Нийтлэг татварын бус орлого	674,494,237.1	94,245,164.8
122	Тусламжийн орлого	-	2,861.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,871,091.1	289,904,712.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	13,728,138.2	53,881,488.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	13,728,138.2	53,881,488.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	12,086,473.0	53,063,430.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,948,395.0	4,800,810.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	321,935.7	541,954.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	246,500.8	249,426.6
2104	Хангамж, бараа материалын зардал	182,820.1	243,324.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	77,657.3	53,109.5
2107	Томилолт, зочны зардал	62,896.7	473,775.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,078,336.0	41,847,918.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,167,931.5	4,853,111.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,641,665.2	818,057.4
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	971,637,190.0	330,271,251.1
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	100,452.4	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	290,164.7	10,765,970.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	971,447,477.7	319,505,280.2

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооноо нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	243,415.5	-	243,415.5
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	243,415.5	-	243,415.5
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(4.4)	-	(4.4)
9	Тайлант үеийн үр дүн	971,447,477.7	-	971,447,477.7
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	971,690,888.8	-	971,690,888.8
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(507,075.0)	-	(507,075.0)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	971,183,813.8	-	971,183,813.8
19	Тайлант үеийн үр дүн	319,505,280.2	-	319,505,280.2
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,290,689,094.0	-	1,290,689,094.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	326,975,607.4	383,841,809.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	16,104,516.4	93,937,097.0
120	Нийтлэг татварын бус орлого	16,104,516.4	93,937,097.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,871,091.1	289,904,712.9
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,303,757.1	16,173,060.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,303,757.1	16,173,060.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,155,017.0	15,347,738.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,897,661.5	4,805,884.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	320,694.4	589,119.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	235,085.6	247,756.5
2104	Хангамж, бараа материалын зардал	195,564.3	195,546.5
2105	Нормативт зардал	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115,171.1	114,997.2
2107	Томилолт, зочны зардал	74,962.4	496,923.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,120,560.2	8,167,312.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,195,317.5	730,197.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,148,740.2	825,322.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	316,671,850.3	367,668,749.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	303,471,448.2	275,594,549.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	303,471,448.2	275,594,549.9
2200	Дотоод эх үүсвэрээр	303,471,448.2	275,594,549.9
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(303,471,448.2)	(275,594,549.9)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	13,200,402.2	92,074,199.9
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	13,200,402.2
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,200,402.2	105,274,602.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	338,831,610,300.00	302,429,097,790.49	36,402,512,509.51	89.3
УРСГАЛ ЗАРДАЛ	16,047,438,000.00	15,142,054,192.21	905,383,807.79	94.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	15,888,238,000.00	15,069,855,419.21	818,382,580.79	94.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,087,999,400.00	4,725,800,819.05	362,198,580.95	92.9
Үндсэн цалин	2,997,865,500.00	2,783,662,029.23	214,203,470.77	92.9
Нэмэгдэл	1,436,219,800.00	1,021,344,127.68	414,875,672.32	71.1
Унаа хоолны хөнгөлөлт	473,505,600.00	559,426,228.71	(85,920,628.71)	118.1
Урамшуулал	180,408,500.00	361,368,433.43	(180,959,933.43)	200.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	653,021,200.00	577,374,650.89	75,646,549.11	88.4
Тэтгэврийн даатгал	427,757,100.00	396,927,254.77	30,829,845.23	92.8
Тэтгэмжийн даатгал	56,977,100.00	46,062,985.69	10,914,114.31	80.8
ҮОМШӨ-ний даатгал	44,879,500.00	36,408,343.22	8,471,156.78	81.1
Ажилгүйдлийн даатгал	11,219,200.00	8,868,420.35	2,350,779.65	79.0
Эрүүл мэндийн даатгал	112,188,300.00	89,107,646.86	23,080,653.14	79.4
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	329,971,400.00	247,756,536.82	82,214,863.18	75.1
Гэрэл, цахилгаан	184,522,600.00	117,108,834.11	67,413,765.89	63.5
Түлш, халаалт	41,496,900.00	30,762,786.62	10,734,113.38	74.1
Цэвэр, бохир ус	33,084,700.00	31,069,936.09	2,014,763.91	93.9
Байрны түрээс	70,867,200.00	68,814,980.00	2,052,220.00	97.1
Хангамж, бараа материалын зардал	208,490,700.00	197,146,504.65	11,344,195.35	94.6
Бичиг хэрэг	74,212,800.00	74,211,174.00	1,626.00	100.0
Тээвэр, шатахуун	44,315,900.00	44,312,500.00	3,400.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	57,529,200.00	46,460,997.65	11,068,202.35	80.8
Ном, хэвлэл	529,900.00	529,900.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,902,900.00	31,631,933.00	270,967.00	99.2
Эд хогшил, урсгал засварын зардал	808,555,400.00	806,443,474.00	2,111,926.00	99.7
Багаж, техник, хэрэгсэл	194,290,500.00	194,272,299.00	18,201.00	100.0
Тавилга	560,893,000.00	560,185,800.00	707,200.00	99.9
Урсгал засвар	53,371,900.00	51,985,375.00	1,386,525.00	97.4
Томилолт, зочны зардал	522,419,200.00	478,419,146.58	44,000,053.42	91.6
Гадаад албан томилолт	433,276,900.00	411,455,579.90	21,821,320.10	95.0
Дотоод албан томилолт	86,142,300.00	63,963,566.68	22,178,733.32	74.3
Зочин төлөөлөгч хүлээн авах	3,000,000.00	3,000,000.00	-	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,148,473,700.00	7,908,316,794.34	240,156,905.66	97.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,918,524,900.00	7,683,136,309.30	235,388,590.70	97.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,960,400.00	7,960,000.00	400.00	100.0
Даатгалын үйлчилгээ	2,280,800.00	2,132,355.00	148,445.00	93.5
Тээврийн хэрэгслийн татвар	777,100.00	646,077.00	131,023.00	83.1
Тээврийн хэрэгслийн оношилгоо	65,000.00	22,000.00	43,000.00	33.8
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	216,379,300.00	211,935,353.04	4,443,946.96	97.9
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,486,200.00	2,484,700.00	1,500.00	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	129,307,000.00	128,597,492.88	709,507.12	99.5
Бараа үйлчилгээний бусад зардал	55,950,200.00	55,852,581.58	97,618.42	99.8
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	73,356,800.00	72,744,911.30	611,888.70	99.2
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	159,200,000.00	72,198,773.00	87,001,227.00	45.4
Засгийн газрын урсгал шилжүүлэг	31,515,500.00	-	31,515,500.00	0.0
Засгийн газрын гадаад шилжүүлэг	31,515,500.00	-	31,515,500.00	0.0
Бусад урсгал шилжүүлэг	127,684,500.00	72,198,773.00	55,485,727.00	56.5
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,804,900.00	50,797,883.00	7,017.00	100.0

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	75,899,400.00	20,420,690.00	55,478,710.00	26.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	980,200.00	980,200.00	-	100.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	322,784,172,300.00	287,287,043,598.28	35,497,128,701.72	89.0
Барилга байгууламж	322,784,172,300.00	287,287,043,598.28	35,497,128,701.72	89.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	338,831,610,300.00	302,429,097,790.49	36,402,512,509.51	89.3
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	338,599,045,800.00	302,309,159,469.49	36,289,886,330.51	89.3
Улсын төсвөөс санхүүжих	338,599,045,800.00	302,309,159,469.49	36,289,886,330.51	89.3
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	232,564,500.00	119,938,321.00	112,626,179.00	51.6
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	232,064,500.00	112,738,321.00	119,326,179.00	48.6
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	500,000.00	7,200,000.00	(6,700,000.00)	1440.0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	484	370	114	76.4
БАЙГУУЛЛАГЫН ТОО	4	4	0	100.0
Төсвийн байгууллага	4	4	0	100.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	240	183	57	76.3
Удирдах ажилтан	45	38	7	84.4
Гүйцэтгэх ажилтан	176	138	38	78.4
Үйлчлэх ажилтан	19	7	12	36.8
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	240	183	57	76.3
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	210	158	52	75.2
Ажлын албаны албан хаагч (АА)	2	2	0	100.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	26	21	5	80.8
Улс төрийн албан хаагч (УТ)	2	2	0	100.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	2	0	2	0.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	2	0	2	0.0

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		1,674,548,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		1,674,548,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		1,638,356,822.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		80,083,687.00
210101	Үндсэн цалин		80,083,687.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		10,717,313.00
210201	Тэтгэврийн даатгал		10,717,313.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		945,955,822.33
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		945,955,822.33
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		601,600,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		601,600,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		36,191,177.67
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		36,191,177.67
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		36,191,177.67
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		1,674,548,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		1,674,548,000.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		127,401,000.00
131103	ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		565,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		980,200,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		1,947,000.00
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 5 байгууллагын тайлан нэгтгэсэнээс 2 байгууллагад “Өөрчлөлтгүй”, 1 байгууллагад “Хязгаарлалттай” дүгнэлт өгч, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар илэрсэн алдаа, зөрчил

Аудитаар нийт 13,695.7 сая төгрөгийн 4 алдаа илэрснийг аудитын явцад залрууллаа.

Залруулсан алдаа:

ЭЗХЯ-аас чөлөөт бүсүүд болон хөрөнгө оруулалт, худалдааны газарт үнэ төлбөргүй шилжүүлсэн 21.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн хоорондын тооцоог үүсгэж, устгах бичилтийг хийгээгүй;

- Хөгжлийн хөтөч дэд бүтэц ТХН-ээс үнэ төлбөргүй шилжүүлсэн 231.3 сая төгрөгийн хөрөнгийн орлогын хоорондын тооцоог баталгаажуулаагүй ;
- Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба санхүүгийн байдлын тайлангийн тайлант оны үр дүнг 13,433.3 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Цагааннуур чөлөөт бүсийн ЗАА ТӨБЗГ-ын 2023 оны А-1/2481 дугаар тогтоолоор ЭЗХЯ-аас балансаас баланст шилжүүлсэн хөрөнгийн 9.4 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн тайланд зөрүүтэй тусгасан.

Аудитаар нийт 115.3 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс, 1 албан шаардлага хүргүүлж, 115.3 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Албан шаардлага

Тайлант онд 38,753.0 сая төгрөгийн өртөгтэй "Нийслэлийн ХУД-т баригдаж байгаа 300 ор бүхий төрөх эмнэлгийн барилгын ажлыг дуусган, дэд бүтэц барих" төслийг балансаас баланст шилжүүлж, өмнөх оны аудитаар өгсөн бусад эргэлтийн хөрөнгө дансанд бүртгэлтэй, бүрэн хэрэгжиж дууссан улсын комисс хүлээн авсан, ашиглагч байгууллагад шилжүүлэх барих-шилжүүлэх төрлийн 12 ажлыг данс бүртгэлээс хасах, эзэмшигч байгууллагад шилжүүлэх асуудлыг ТӨБЗГ-аар шийдвэрлүүлэх талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах" Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ", МУЕА-ын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, бусад эргэлтийн хөрөнгө дансанд хуримтлуулж бүртгэсэн шилжүүлэх боломжтой 3 хөрөнгө оруулалтын арга хэмжээг эцсийн захиалагчид шилжүүлэх ажлыг зохион байгуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Улсын төсвийн орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг боловсруулж, батлуулаагүй боловч “Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны буудлын менежментийн төсөл”-ийг хэрэгжүүлэх 15 жилийн хугацаатай концессын гэрээний тайлант оны төлбөр 8,495.2 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” 22 дугаар зүйлийн 22.6.3-т “төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналтыг төсвийн ангиллын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Концессын гэрээний нөхөн төлбөрийн дүнг тооцож, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг батлуулж байх.

2. Харьяа байгууллагуудтай холбоотой асуудал

Илрүүлэлт: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 5,701.6 сая төгрөгийн 3 алдаа, 115.3 сая төгрөгийн 11 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 192.0 сая төгрөгийн 3 зөрчил илэрсэн бөгөөд ХШҮДАГ нь тайлант онд харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 14.2.10-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3-т “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн мөнгөн хөрөнгийн зарцуулалттай холбоотой зөрчил нь нийт зөрчлийн 90 хувь буюу 91.0 сая төгрөг байгаа тул дараагийн төсвийн жилд нийт зөрчлийн дүнг 20.0 хувиар бууруулж ажиллах .

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитаар нийт 19,396.3 сая төгрөгийн 7 алдаа илэрснээс аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллага нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								Тоо	Дүн	Тоо	Дүн		
1	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	2	253.0	1	21.6	1	231.3	2	253.0				
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Эдийн засаг, хөгжлийн яам	2	5,674.0	2	5,674.0			2	5,674.0				
2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	26.6			1	26.6	1	26.6				
ТҮҮВРИЙН БАЙГУУЛЛАГА													
1	Цагааннуур чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	1	9.4			1	9.4	1	9.4				
2	Замын-Үүд чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	1	13,433.3			1	13,433.3	1	13,433.3				
Нийт дүн		7	19,396.3	3	5,695.6	4	13,700.6	7	19,396.3	-	-	-	-

Аудитаар нийт 230.5 сая төгрөгийн 14 зөрчил илэрснээс, 0.2 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 84.2 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 146.1 сая төгрөгийн 8 зөрчилд зөвлөмж өгсөн байна.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

№	Байгууллага нэр	Нийт зөрчил		Үүнээс									
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	3	115.3			1	-	2	115.3				
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ													
1	Эдийн засаг, хөгжлийн яам	6	58.8			1	52.8	5	6.0				
2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	3	31.9			2	7.1	1	24.8				
3	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	2	24.5	1	0.2	1	24.3						
Нийт дүн		14	230.5	1	0.2	5	84.2	8	146.1	-	-	-	-

Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 192.1 сая төгрөгийн 4 зөрчил илэрснээс 152.1 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 40.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр

№	Байгууллага нэр	Нийт зөрчил		Үүнээс						
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
1	Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	1	-					1	-	
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ										
1	Эдийн засаг, хөгжлийн яам	1	-			1	-			
2	Хөрөнгө оруулалт, худалдааны газар	1	40.0					1	40.0	
3	Алтанбулаг чөлөөт бүсийн захирагчийн ажлын алба	1	152.1			1	152.1			
Нийт дүн		4	192.1			-	2	152.1	2	40.0